



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/05-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Т.Одсүрэн Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
З.ТҮВШИНТӨГС ТАНАА

2023.02.25. № 00А-2023/05-КАСТА-743
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн БОАЖГ-ын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 96.8 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 2.3 хувиар, НДШ-ийн зардлыг 4.6 хувиар, томилолтын зардлыг 3.2 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 9.2 хувиар, бараа үйлчилгээний зардлыг 3.9 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 3.2 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн БОАЖГ-ын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 68.7 хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний зардал эзэлж байгаа бөгөөд цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 596,219.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 16,580.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 13,400.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 6,486.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,937,422.00	20,144,433.00
33	АВЛАГА	80,000,000.00	-
33500	Бусад авлага	80,000,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	80,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	27,937,422.00	20,144,433.00
35100	Түүхий эд материал	1,500,000.00	1,500,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,500,000.00	1,500,000.00
35400	Хангамжийн материал	26,437,422.00	18,644,433.00
35410	Бичиг хэргийн материал	2,600,050.00	2,193,000.00
35420	Аж ахуйн материал	462,000.00	841,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	938,800.00	-
35440	Түлш, шатах тослох материал	3,836,139.00	610,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,600,433.00	15,000,433.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	175,926,014.99	150,889,617.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	175,926,014.99	150,889,617.46
39200	Биет хөрөнгө	110,920,498.22	98,033,463.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,838,740.00	5,838,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,502,317.16)	(3,127,896.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,950,000.00	55,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,743,750.31)	(19,362,500.19)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	50,690,600.00	70,010,685.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,623,622.73)	(37,236,722.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,201,070.00	24,601,070.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,745,446.58)	(11,221,331.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,600,300.00	21,600,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,745,075.00)	(9,018,881.25)
39300	Биет бус хөрөнгө	65,005,516.77	52,856,154.33
39301	Програм хангамж	65,147,600.00	65,147,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(342,083.23)	(12,491,445.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	200,000.00	200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	283,863,436.99	171,034,050.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	283,863,436.99	171,034,050.46
51	Засгийн газрын хувь оролцоо	283,863,436.99	171,034,050.46
51100	Засгийн газрын оруулсан капитал	121,834,119.85	121,834,119.85
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	121,834,119.85	121,834,119.85
51200	Хуримтлагдсан үр дүн	160,644,094.02	47,814,707.49
51210	Өмнөх үеийн үр дүн	27,858,812.98	160,644,094.02
51220	Тайлант үеийн үр дүн	132,785,281.04	(112,829,386.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,385,223.12	1,385,223.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	283,863,436.99	171,034,050.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,305,429,251.10	2,138,555,512.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,064,785.00	75,480,073.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,064,785.00	75,480,073.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	480,000.00	74,970,073.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	584,785.00	510,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,304,364,466.10	2,063,075,439.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,500,000.00	19,902,576.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	19,832,576.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81,000,000.00	70,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,222,864,466.10	2,043,172,863.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,222,864,466.10	2,043,172,863.18
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,163,689,573.04	2,056,359,106.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,163,689,573.04	2,056,359,106.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,143,077,833.04	2,049,872,592.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,529,167.46	529,302,255.00
210101	Үндсэн цалин	382,052,287.16	422,773,847.00
210102	Нэмэгдэл	105,732,829.86	59,599,066.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,989,485.44	23,895,000.00
210104	Урамшуулал	38,754,565.00	23,034,342.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,051,977.64	66,916,944.18
210201	Тэтгэврийн даатгал	49,842,119.19	46,393,118.34
210202	Тэтгэмжийн даатгал	5,533,754.90	5,465,990.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,410,201.87	4,241,752.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,024,172.30	983,279.43
210205	Эрүүл мэндийн даатгал	10,241,729.38	9,832,803.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,935,400.00	-
210304	Байрны түрээс	1,935,400.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	28,573,191.00	43,013,654.00
210401	Бичиг хэрэг	2,688,250.00	3,883,850.00
210402	Тээвэр, шатахуун	17,650,500.00	23,185,139.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,246,491.00	1,271,710.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	3,684,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,244,950.00	10,988,955.00
210408	Бараа материал акталсны зардал	5,683,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	490,000.00	8,938,800.00
210604	Урсгал засвар	490,000.00	8,938,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,085,500.00	11,342,300.00
210702	Дотоод албан томилолт	4,085,500.00	11,342,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,826,430.00	21,824,550.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	68,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	320,550.00	297,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,100.00	470,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,140,500.00	20,743,000.00
210807	Газрын төлбөр	140,280.00	168,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	477,586,166.94	1,368,534,089.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	439,888,656.00	1,328,067,607.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	210,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,697,510.94	40,256,482.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,611,740.00	6,486,514.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,611,740.00	6,486,514.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,719,000.00	6,486,514.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,892,740.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	141,739,678.06	82,196,405.26
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,954,397.02	195,025,791.79
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	754,397.02	84,470,072.79
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,200,000.00	110,555,719.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	132,785,281.04	(112,829,386.53)
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,304,364,466.10	2,143,075,439.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,304,364,466.10	2,143,075,439.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,500,000.00	99,902,576.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	81,000,000.00	99,832,576.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,222,864,466.10	2,043,172,863.18
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,222,864,466.10	2,043,172,863.18
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,215,221,866.10	2,038,355,354.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,215,221,866.10	2,038,355,354.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,113,564,126.10	2,031,868,840.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,529,165.46	529,302,253.37
210101	Үндсэн цалин	382,052,285.16	423,519,642.58
210102	Нэмэгдэл	105,732,829.86	58,853,268.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,989,485.44	23,895,000.00
210104	Урамшуулал	38,754,565.00	23,034,342.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,051,979.64	66,916,945.81

210201	Тэтгэврийн даатгал	49,842,119.19	46,409,919.97
210202	Тэтгэмжийн даатгал	5,533,754.90	5,449,190.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,410,203.87	4,241,752.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,024,172.30	983,279.43
210205	Эрүүл мэндийн даатгал	10,241,729.38	9,832,803.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,935,400.00	-
210304	Байрны түрээс	1,935,400.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	14,046,341.00	16,650,465.00
210401	Бичиг хэрэг	2,128,400.00	2,727,100.00
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,332,891.00	1,271,710.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,050.00	1,667,655.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,428,800.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	1,428,800.00	8,000,000.00
2107	Томилот, зочны зардал	2,417,500.00	5,228,900.00
210702	Дотоод албан томилот	2,417,500.00	5,228,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,826,430.00	1,544,550.00
210803	Даатгалын үйлчилгээ	320,550.00	297,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,100.00	470,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,140,500.00	463,000.00
210807	Газрын төлбөр	140,280.00	168,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	463,328,510.00	1,404,225,726.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	463,328,510.00	1,484,015,726.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	210,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,657,740.00	6,486,514.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,657,740.00	6,486,514.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,765,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,892,740.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	6,486,514.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	80,000,000.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	80,000,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	89,142,600.00	104,720,085.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	89,142,600.00	24,720,085.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,142,600.00	24,720,085.00
2200	Дотоод эх үүсвэрээр	89,142,600.00	24,720,085.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	89,142,600.00	24,720,085.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(89,142,600.00)	(24,720,085.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	27,858,812.98	151,078,155.95
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	27,858,812.98	151,078,155.95
9	Тайлант үеийн үр дүн	0	0	132,785,281.04	132,785,281.04
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	160,644,094.02	283,863,436.99
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	160,644,094.02	283,863,436.99
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	160,644,094.02	283,863,436.99
19	Тайлант үеийн үр дүн	0	0	(112,829,386.53)	(112,829,386.53)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	47,814,707.49	171,034,050.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,111,613,400.00	2,043,172,863.18	68,440,536.82	96.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,111,613,400.00	2,043,172,863.18	68,440,536.82	96.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,105,113,400.00	2,036,686,349.18	68,427,050.82	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	537,690,500.00	529,302,253.37	8,388,246.63	98.4
210101	Үндсэн цалин	433,636,700.00	423,519,642.58	10,117,057.42	97.7
210102	Нэмэгдэл	58,455,200.00	58,853,268.79	(398,068.79)	100.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,696,000.00	23,895,000.00	3,801,000.00	86.3
210104	Урамшуулал	17,902,600.00	23,034,342.00	(5,131,742.00)	128.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,109,800.00	66,916,945.81	3,192,854.19	95.4
210201	Тэтгэврийн даатгал	47,674,600.00	46,409,919.97	1,264,680.03	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,608,800.00	5,449,190.05	159,609.95	97.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,487,000.00	4,241,752.39	245,247.61	94.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,121,800.00	983,279.43	138,520.57	87.7
210205	Эрүүл мэндийн даатгал	11,217,600.00	9,832,803.97	1,384,796.03	87.7
2104	Хангамж, бараа материалын зардал	16,602,500.00	16,580,465.00	22,035.00	99.9
210401	Бичиг хэрэг	2,515,600.00	2,657,100.00	(141,500.00)	105.6
210402	Тээвэр, шатахуун	11,290,000.00	10,900,000.00	390,000.00	96.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,440,000.00	1,271,710.00	168,290.00	88.3
210404	Ном, хэвлэл	130,000.00	84,000.00	46,000.00	64.6

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,226,900.00	1,667,655.00	(440,755.00)	135.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,400,000.00	13,400,000.00	-	100.0
210602	Тавилга	5,400,000.00	5,400,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	5,400,000.00	5,228,900.00	171,100.00	96.8
210702	Дотоод албан томилолт	5,400,000.00	5,228,900.00	171,100.00	96.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,700,600.00	1,544,550.00	156,050.00	90.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,100.00	68,100.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	297,500.00	297,450.00	50.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	489,200.00	470,200.00	19,000.00	96.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	463,000.00	137,000.00	77.2
210807	Газрын төлбөр	168,800.00	168,800.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,460,210,000.00	1,403,713,235.00	56,496,765.00	96.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,460,000,000.00	1,403,503,235.00	56,496,765.00	96.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	210,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	6,486,514.00	13,486.00	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	6,486,514.00	13,486.00	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	6,486,514.00	13,486.00	99.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,111,613,400.00	2,043,172,863.18	68,440,536.82	96.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,111,613,400.00	2,043,172,863.18	68,440,536.82	96.8
320001	Орон нутгийн төсвөөс	2,111,613,400.00	2,043,172,863.18	68,440,536.82	96.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58	50	8.00	86.2
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	55	48	7.00	87.3
620003	Үйлчлэх ажилтан	2	1	1.00	50.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	58	50	8.00	86.2
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	53	46	7.00	86.8
650002	Төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮ)	5	4	1	80.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,902,576.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,902,576.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,902,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,000.00
210401	Бичиг хэрэг	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,832,576.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,832,576.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	99,902,576.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	99,902,576.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	99,832,567.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь цаашид (Сэлэнгэ аймгийн БОАЖГ) *“Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн хууль тогтоомжуудыг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх замаар байгаль орчны тэнцлийг хангаж, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчны багц хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх,
- Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх,
- Байгаль орчны сургалт, сурталчилгааны ажлыг гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах
- Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах
- Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батдагдсан “Төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишигт 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн БОАЖГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2020 оны А/202 дугаар захирамжаар түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн БОАЖГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 112,829.4 мянган төгрөгөөр буюу 39.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	80,000.00	-	(80,000.00)
Бараа материал	27,937.42	20,144.43	(7,792.99)
Үндсэн хөрөнгө	175,926.01	150,889.62	(25,036.39)
Нийт хөрөнгө	283,863.43	171,034.05	(112,829.38)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	283,863.43	171,034.05	(112,829.38)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	283,863.43	171,034.05	(112,829.38)

Авлагын данс оны эхэнд татаас санхүүжилтийн 80,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол БОАЖС-ын 2021 оны 11 сарын 25-ны өдрийн А/27 дугаар тушаалын дагуу орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд “Хот суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох” ажлын санхүүжилтийг авч холбогдох байгууллагуудад шилжүүлснээс оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 243,348.4 мянган төгрөг болж 32,279.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 24,720.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, үнэ төлбөргүйгээр БОАЖЯ-аас түймэр унтраах зориулалттай 74,970.1 мянган төгрөгийн автомашин шилжүүлэн авсан болон аймгийн ИТХ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор Баруунбүрэн, Хүдэр сумын ЗДТГ-т 131,970.1 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 171,034.0 мянган төгрөг болж 112,829.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд 830,117.3 мянган төгрөг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд 1,460,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,290,117.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа ажил үйлчилгээний зардлыг 178,503.8 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг 651,613.4 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд 1,460,000.0 мянган төгрөг, нийт төсвийг 2,111,613.4 мянган төгрөг баталсан байна. Энэ нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, тээвэр шатахуун, нормын хувцас зөөлөн эдлэл, томилолт зэрэг зардлуудыг бууруулсан зэргээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй бөгөөд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,111,613.4 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,043,172.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,043,172.9 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 8,388.2 мянган төгрөг, НДШ-ийн зардлаас 3,192.9 мянган төгрөг, хангамжийн материалын зардлаас 22.0 мянган төгрөг, томилолтын зардлаас 171.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжаас 156.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 56,496.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 13.5 мянган төгрөгийг тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр,	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	71413- Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	645,113.4	633,183.1	11,930.3	98.2
2		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	6,500.0	6,486.5	13.5	99.8
3		81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,460,000.0	1,403,503.2	56,496.8	96.1
Нийт			2,111,613.4	2,043,172.9	68,440.5	96.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд БОАЖС-ын 2021 оны 11 сарын 25-ны өдрийн А/27 тоот “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дагуу орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд “Хот суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох” ажлыг санхүүжүүлэхэд 99,832.6 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 70.0 мянган төгрөг зэрэг нийт 99,902.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу БОАЖГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтыг үнэн зөв хөтөлж, шатахууны зарцуулалтыг бодитоор тайлагнаж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

БОАЖГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 21 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал зардлын 1,163,689.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,636.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах төсвийн зарлагын чиглэлээр орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулахад тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

4.3.1 Энэ хуулийн хүрээнд томилолт, шатахуун, бичиг хэргийн зардал 362.7 мянган төгрөг, орон тоог хязгаарлах замаар нэмж ажилтан аваагүйгээс цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 11,581.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд тусгагдсан байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 56,496.8 мянган төгрөг зэрэг нийт **68,440.5** мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд БОАЖГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Байгаль орчны нөхөн сэргээх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр сонгон шалгарсан дараах ААНБ-тай урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр 50-70 хувиар урьдчилгаа төлбөр олгох гэрээ байгуулж санхүүжилтийг урьдчилж олгосон байна. Үүнд:

- Ойн хүрэм ХХК-тай байгуулсан “Ойн зурвас байгуулах”, “Ойжуулалтын ажил”-ын төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтийг 50-70 хувиар олгохоор тооцож нийт 113,845.9 мянган төгрөг,
- Тэнгэрлэг-Ой ХХК-тай байгуулсан “Ногоон төгөл байгуулах” төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 50 хувь буюу 46,400.0 мянган төгрөг,
- Сэлэнгэ Ундрам ХХК-тай байгуулсан “Хөв цөөрөм байгуулах” төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 70 хувь буюу 111,937.5 мянган төгрөг,
- Агро Форест ХХК-тай байгуулсан “Ойн зурвас байгуулах” төсөл арга хэмжээнд урьдчилгаа санхүүжилт олгохгүйгээр гүйцэтгэсэн ажлын актаар хүлээн авсны дараа санхүүжилтийг бүрэн олгохоор гэрээнд заасан боловч 70 хувийн буюу 38,372.0 мянган төгрөг зэрэг нийт 310,555.4 мянган төгрөгийн урьдчилгааг тус тус олгосон байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь “Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө”, Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 41.1-т заасан “Урьдчилгаа төлбөр олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх ажил үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, тендерийн баримт бичигт заасан шалгуурт нийцүүлэн зохион байгуулж урьдчилгаа төлбөр олгох тохиолдолд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлээгүй 1 албан шаардлага, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй **6,731.3** мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж тайлант онд давтан гаргаагүй ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2360.1	1	2360.1	100%
Зөвлөмж	2	6,731.3	2	6,731.3	100%
Нийт дүн	3	9,091.4	3	9,091.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Тайлант онд аймгийн ИТХ-ын 2021 оны 25 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “*Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх*” төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг аудитын явцад түүвэрлэн үзсэн бөгөөд тендер сонгон шалгаруулалтай холбоотой асуудлыг аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитад бүрэн хамруулаагүй болно.

Иймд ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар тус төсөл, арга хэмжээний тендерийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй байна.

2. Нягтлан бодогч Б.Минжээгийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40.0 хувиар тооцож олгосон боловч аймгийн Засаг даргын 2022 Б/29 дүгээр захирамжийг үндэслэн БОАЖГ-ын даргын

2022 оны Б/30 дугаар тушаалаар байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг, хууль журам стандартын дагуу бэлтгэж аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэх үндэслэлээр 1,196.5 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх” Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3:” Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Үндэслэлгүйгээр урамшууллыг давхардуулан олгох шийдвэр гаргасан асуудлыг аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэх шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80,000.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Дансны ангилал буруу тайлагнаж нэмэлт санхүүжилтийн 80,000 мянган төгрөгийн орлогыг зардлын дансаар бүртгэсэн 1 алдааг залруулав.

Аудитаар нийт **2,547.6** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 548.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **1,998.7** мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 2 албан хаагчийн ажил хавсарсны нэмэгдлийг бодогдсон цалингаас бус үндсэн цалингаас тооцож 548.9 мянган төгрөг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 548.9 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тээврийн хэрэгслийн тухайн сарын зарцуулалтыг хэд хэдэн тооцооны хуудас давхардуулан нээж хөтөлсөн, спидометрийн заалтыг өмнөх болон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дараах сарын заалтаас зөрүүтэй бичсэн зэргээр 1,998.7 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг бодитоор тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын холбогдох заалтыг тус тус зөрчиж байгаа

1.2 Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг баталсан маягт, аргачлалын дагуу үнэн зөв хөтөлж, шатахууны зарцуулалтыг баталгаажуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дансны ангилал буруу тайлагнаж орлогоор бус зардлаар бүртгэсэн алдааг залруулсан.	1	80,000.0			1	80,000.0	1	80,000.0				
Дүн	1	80,000.0			1	80,000.0	1	80,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн тооцооллыг хянаагүйгээс хавсран ажилласны нэмэгдлийг илүү олгосон	1	548.9	1	548.9								
Жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв хөтлөөгүй	1	1,998.7					1	1,998.7				
Дүн	2	2,547.6	1	548.9			1	1,998.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Байгаль хамгаалах нөхөн сэргээх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр сонгон шалгарсан ААНБ-тай гэрээ байгуулахдаа санхүүжилтийн урьдчилгааг 50-70 хувиар олгохдоо урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр олгосон	1	310,555.4								1	310,555.4	
Дүн	1	310,555.4								1	310,555.4	